

Нарийн бичгийн

дарга: Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын Барилга хот
байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн

2. Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалттай барилга байгууламж, төсөл арга хэмжээнд барилгын техникийн хяналт хийх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга, байгууламж, төсөл арга хэмжээнд барилгын техникийн хяналтыг үр дүнтэй хийж, ажлын гүйцэтгэл, үр дүнгийн тайланг сар бүр Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Р.Цэдэнбал/-д үүрэг болгосугай.

4. Барилгын техникийн хяналт хийхтэй холбогдон гаргах зардлыг Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай барилгын техникийн хяналтын зардлаас ажлын тайлан, гүйцэтгэлийг хянаж олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтийг ханган ажлын хэсгийг унаа, шатахуун, урамшуулал, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, гэрээ байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/273

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын үр өгөөжийг сайжруулах зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга, байгууламж, төсөл арга хэмжээнд барилгын техникийн хяналт хийх иргэд, мэргэжлийн байгууллагын төлөөллүүдийг оролцуулсан хөндлөнгийн орон тооны бус ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:	Р.Цэдэнбал	- Монгол улсын гавъяат барилгачин
Гишүүд:	Р.Сандуйжав	- Монгол улсын гавъяат барилгачин
	Д.Шуурай	- Барилгын материалын технологич инженер
	Б.Түмэндэмбэрэл	- Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Д.Эрдэнэбат	- Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
	Б.Загджүсүм	- Сэргээгдэх эрчим хүчний инженер
	Н.Амаржаргал	- Шугам сүлжээний инженер
	Г.Баатарболд	- Иргэний ба үйлдвэрийн барилгын инженер

Zax A/273 Kh

02 1529